



НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2013 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 5/83

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5 дахь заалтууд, Албаны даргын 2013 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн Б/63 тоот тушаалын гуравдугаар хэвсрэлт, Даргын дэргэдэх зөвлөлийн 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 05 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын дунд зарласан болзолт уралдааны удирдамжийн дагуу хамт олноо манлайлан тэргүүлсэн мэргэжилтэн Э.Эрдэнэбаатар, О.Алтангэрэл, М.Отгонбаяр, жолооч Ч.Өлзийбат нарт гадаадад аялах эрхийн бичиг олгож, энэхүү ажлыг зохион байгуулж, албаны удирдлагад тайлагнан ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс /Ч.Цог/-т даалгасугай.

2. Аялалын зардалд зарцуулах 5,880,000 /таван сая найман зуун наян мянга/ төгрөгийг урьд оны төсвийн хэмнэлтийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН